

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ишдоо	Дугаар	Л119
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Өндөрхаан
Төрсөн газар		Төрсөн он	1919
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хужиртын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭГЛ 054
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд

Хэнтий аймгийн Галшар сумын Хужиртын хийд

-Та ямар хийдэд хүрж байсан бэ? Өөрийн сууж байсан хийдийнхээ тухай ярьж өгөөч?

Галшар сүм гэдэг чинь хуучин Хардэл жанжин бэйсийн хошуу. Би 7 настайдаа лам болоод Ганданшадавдаржаалинд 17, 18 хүртлээ сууж байсан. Хийдийн баруун урд Дондой гэдэг уул байдаг.

-Та сууж байсан Ганданшадавдаржаалин буюу Хужиртын хийдийнхээ тухай яриач? Хэдэн онд байгуулагдсан? Хэр олон ламтай, хэдэн дугантай хийд байсан бэ?

Тэнд Чойр дугандаа дамжаа барьдаг байсан. 4 аймгийн дуган, Манба, Жүд, Гол дуган, Ганжуур дуган гэж байсан.

-Дөрвөн аймгийн дуганын нэр нь юу гэдэг байсан бэ?

Дамчаалин, Даржаалин, Дэмчиглин, Дашлин гэдэг байсан. Цогчэн дуганд 1000 лам багтдаг том дуган байсан. Надад нэг санал байна. Энэ Хужиртын хийдийг нэг сэргээмээр байна. Тэр сууринг ч гэсэн жаахан хөгжүүлмээр байна.